

МОНГОЛ УЛСЫН ГУРАВДАГЧ ХӨРШ АСЕАН

Б.Цэнгэлхам*

Уг өгүүлэлээр манай орны олон тулгуурт гадаад бодлогын хүрээнд хамтран ажиллах боломжтой хэдий ч харьцангуй бага яригддаг нэгэн чиглэл болох АСЕАН-ы талаар товч ойлголт өгч, санаа бодлоо хуваалцахыг зорилоо.

Манай орны гуравдагч хөршийн бодлогод тусгах АСЕАН-ы дүр зураг

Түүхээс үзвэл хоёр хөршийн “хайчин бодлогоос”¹ сэрэмжлэн ХХ зууны эхээр барууны томоохон орнуудад хандан, Чин Ван Ханддорж тэргүүтэй хүмүүс туслалцаа хүссэн захиаг илгээж байсан боловч тухайн үед цаг нь болоогүй, нөхцөл нь ч бүрдээгүй байжээ. Хоёрхон том хөрштэй манай орны хувьд аль нэгнийх нь нөлөөнд орохгүйн тулд “олон тулгуурт” гадаад бодлого баримтлах зайлшгүй шаардлага байсан байдаг. Иймээс тэд² гадаад бодлогынхоо амин зорилго болох өөрийн орны тусгаар тогтнолоо хүчтэй улсын “дагуул улс” байдлаар хамгаалахаас өөр аргагүйд хүрчээ. Чухам тэр үеэс “Гуравдагч хөрш, гурав дахь цонх” хэмээх ойлголтуудын анхны хэлбэрүүд үүссэн бололтой.³ Харин олон улсын харилцааны шинэ дэг журмын хүрээнд “Гурав дахь хөрш гэдэг нь зөвхөн газар зүйн ойлголт бус, улс төр, эдийн засгийн хүрээг хамарсан ойлголт бөгөөд энэ нь бас Монгол Улсын ардчиллыг тууштай дэмжигч өрнө, дорнын орнуудын бүлэг болон НҮБ зэрэг дэлхийн бодлогод жин нөлөөтэй субъектыг оруулж буй хам ойлголт”⁴ хэмээн тодорхойлогджээ. Үүнийг “ухаж” ойлговол “гурав дахь хөрш” гэдэг нь зөвхөн тодорхой хэсэг бүлэг улс орнууд руу чиглэсэн ойлголт бус АСЕАН зэрэг олон талт хамтын ажиллагааны чиглэлийг давхар цаанаа агуулж буй маш өргөн ойлголт болох нь тодорхой харагдаж байна. Нөгөөтэйгүүр 1994 оны Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлалд: “Монгол Улсын гадаад бодлогын гурав дахь чиглэл бол Азийн бүс нутагт байр сууриа бататгаж эндхийн улс төр, эдийн засгийн интеграцид оновчтой оролцох явдал мөн.... Ази, Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага /АПЕК/-д элсэн орохыг зорино. Бүс нутгийн интеграцид орох нөхцлийг юуны өмнө түүнд хамаарч буй улс орнуудтай хоёр талын харилцааг өргөтгөн хөгжүүлэх замаар бүрдүүлнэ”⁵ гэж зааж өгсөн бөгөөд энэхүү АПЕК-т гишүүнчлэх асуудалд хоёр талын болон олон талт хэлбэрээр АСЕАН-ы гишүүн орнуудтай харилцаа, хамтын ажиллагаагаа өргөжүүлэх замаар дам таатай орчинг бий болгох бүрэн үндэстэй юм. АСЕАН-ы гишүүн 10 орны Лаос, Камбож, Мяньюмараас /Бирм/ бусад 7 улс нь АПЕК-ын гишүүд бөгөөд

* Б.Цэнгэлхам - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан

гишүүд дотроо нилээд нэр хүндтэйд тооцогддог юм. Манай орон АСЕАН-ы найрамдал хамтын ажиллагааны гэрээнд 2005 оны 7 дугаар сард, АРФ-ын гишүүнээр 2006 оны 8 сард тус тус элсээд байгаа юм.

Олон улсын тавцанд АСЕАН-ы эзлэх жин нөлөө

1967 онд бүс нутагтаа эдийн засгийн өсөлт, нийгэм соёлын хөгжлийг хурдасгах, бүс нутгийн энх тайван, тогтвортой байдлыг хангах гэсэн хоёр үндсэн зорилготойгоор АСЕАН /Зүүн Өмнөд Азийн Улсуудын Холбоо/ нь анх байгуулагдсан бөгөөд анхны гишүүн 5 орны гадаад хэргийн сайд нар Тайландын нийслэл Бангкок хотноо хамтарсан хуралдаан хийснээр албан ёсоор байгуулагдсан гэж үздэг. Одоогийн байдлаар Тайланд, Малайз, Сингапур, Индонези, Филиппин, Бруней, Вьетнам, Лаос, Бирм, Кампучи гэсэн 10 гишүүн оронтойгоор үйл ажиллагаагаа явуулж байна /Хавсралт №1/. АСЕАН-ы гол зорилго нь бүс нутгийн ард түмний ая тухтай тайван амьдралын үндэс суурийг бэхжүүлж, тэгш эрхтэй, харилцан ашигтай хамтарч ажиллаж, бүс нутгийн эдийн засгийн өсөлт нийгмийн дэвшил болон соёлын хөгжлийг хурдасгах, бүс нутгийн харилцаанд шударга ёс, хуулийн хэм хэмжээг хүндэтгэн мөрдөж, НҮБ-ын дүрэмд заасан зарчмуудыг чанд баримтлан бүс нутгийн энх тайван, тогтвортой байдлыг дэмжих явдал ажээ. Түүнчлэн АСЕАН нь дараах 5 зарчимд⁶ тулгуурлан үйл ажиллагаагаа явуулдаг. Үүнд:

1. Бүх үндэстний тусгаар тогтнол, эрх тэгш байдлыг харилцан хүндэтгэх
2. Улс бүр гаднын ямар нэг нөлөөллөөс чөлөөтэй гарах эрхтэй байх
3. Нэг нэгнийхээ дотоод үйл ажиллагаанд харилцан оролцохгүй байх
4. Маргаантай асуудлыг тайван замаар шийдвэрлэх
5. Харилцан үр өгөөжтэй хамтран ажиллах

Эртний түүхээсээ л уг бүс нутаг далайн тээвэр, худалдааны чухал ач холбогдолтой газар нутаг байсаар ирсэн олон баримт байдаг. Нөгөөтэйгүүр тэд эдийн засгийн өндөр чадавхитай Япон, Солонгос, Австрали асар хурдацтайгаар дэлхийг айлган хөгжиж буй БНХАУ, мэдээллийн технологийн дэлхийн ажлын талбар Энэтхэгтэй газар зүйн хувьд ойр оршдог нь уг бүс нутгийг олон улсын сонирхолын төвд аваачиж байгаа төдийгүй Зүүн Азийн ихэнхи орнуудын Ойрхи Дорнодоос импортлон авч буй газрын тос ба бусад орноос авч буй бараа бүтээгдэхүүнүүд нь чухам уг бүс нутгаар дамжин өнгөрдөг байна. Тэр дундаа Өмнөд Хятадын тэнгист орших Спратлийн⁷ арлуудын газар зүйн байршил нь эдийн засаг, батлан хамгаалах, аюулгүй байдлын тавцанд стратегийн онцгой чухал түшиц газарт тооцогддог тул өнөөг хүртэл газар нутгийн маргаантай явж ирсэн байна. Түүнчлэн тус бүс нутагт гадаад болон дотоод хүчин зүйлсээс үүдэлтэй зарим маргаантай, шийдвэрээ хүлээж буй асуудлууд олон байдгаас онцлон дурьдвал, олон үндэстэн, соёл, шашин нэгэн зэрэг оршин байдаг

нь тус бүсийн улс орнуудыг дотоод зөрчилдөөнд түлхэж, зөрчил мөргөлдөөн үүсгэн тогтворгүй байдал руу түлхдэг бол нөгөө талаас байгалийн гамшиг, элдэв гай гамшигт энэ бүс нутаг ихээхэн өртдөг байна. Мөн уг бүс нутаг их гүрнүүдийн ашиг сонирхолын хүчтэй огтлолцол дээр дурьдсан шалтгаануудаар оршин байдгийг мартаж болохгүй. Харин ийм тийм гэсэн зовлон бэрхшээл ихтэй уг бүс нутаг хөгжин дэвшиж урагшлан дээшилж буйн цаад нууц нь бүсийн улс орнуудыг амжилттайгаар нэгтгэн чиглүүлж, гадаад бодлогын таатай орчинг бүрдүүлэх чиглэлд асар санаачлагатай ажиллаж буй АСЕАН юм. Мөн АСЕАН нь АФТА буюу Чөлөөт худалдааны бүс (1992 он), АРФ буюу АСЕАН-ны Бүсийн Чуулган (1994 он), АСЕАН+3 (БНХАУ, Япон, БНСУ, 1997 он), АСЕАН+1 (БНХАУ, Япон, БНСУ, ОХУ, БНЭУ, 1997 он) гэсэн хамтын ажиллагааны механизмудтай.⁸

1980-аад оны эцэст хүйтэн дайн шувтарч олон улсын байдал эргэлтийн шинжтэй өөрчлөлт гарсан явдал АСЕАН-ы эдийн засгийн хамтын ажиллагааг улам хүчтэй болгов. Энэ үеэс АСЕАН улс төрийн гэхээсээ эдийн засгийн хамтын ажиллагааг чухалчилсан бүлэглэл болсон байна.⁹ АСЕАН-ы гишүүн орнууд эдийн засаг, зах зээлийн салбарт нягт хамтран ажиллахын зэрэгцээ зах зээлийн ертөнц дэх хамтын ажиллагааны жам ёсны зүй тогтлын дагуу ширүүн өрсөлдөөн дунд оршин тогтнодог. Ялангуяа АСЕАН-ы гишүүн орнуудын ихэнх экспортын бүтээгдэхүүн нь адил төрлийн, хөрөнгө оруулалтын эрэлт шаардлага гэх мэт онцлог нь өрсөлдөөнийг нэмэгдүүлэх үндсэн шалтгаан болж байна.¹⁰

1992 онд Сингапурт болсон АСЕАН-ны дээд хэмжээний уулзалтаас “АСЕАН-ыг сонирхогч улс орон, олон улсын байгууллагуудтай харилцаагаа өргөжүүлэх, тэдэнтэй улс төр, эдийн засгийн хамтын ажиллагааны төвшинг дээшлүүлэх, харилцааны хүрээг аюулгүй байдлын салбарт өргөжүүлэх, эдийн засгийн хамтын ажиллагааг гадагш тэлэх, худалдааны чөлөөт бүсийг бий болгох” гэх мэт олон чухал шийдвэрүүдийг гаргасан байна.¹¹

Хамгийн сүүлд 2007 оны 11 сарын 20, 21-нд Сингапур улсад болсон 11 дэх удаагийн дээд хэмжээний уулзалтынхаа үеэр тэд Япон, БНСУ, БНХАУ, Энэтхэг, Австрали улсуудтай тусгайлсан өндөр хэмжээний уулзалтуудыг хийсэн бөгөөд АСЕАН-Японы эдийн засгийн иж бүрэн хамтын ажиллагааны хэлэлцээрт хүрсэн хамтарсан мэдэгдэл, АСЕАН-Австралийн иж бүрэн харилцааны хамтарсан тунхагийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр баталсан тухай тус тус мэдээллээд байна.¹³ Цаашид АСЕАН-ы энэхүү чадварлаг бүтэц дээр тулгуурласан Зүүн Азийн Холбоо байгуулах санал нэлээд эрчимтэй яригдаж байгаа бөгөөд Зүүн Азийн Дээд хэмжээний 3 дахь уулзалт (EAS) өнгөрөгч 11-р сарын 21-нд АСЕАН-ы гишүүн орнууд, БНХАУ, Япон, БНСУ, Шинэ Зеланд, Австралийн бүрэлдэхүүнтэйгээр хуралдсан. Одоогоор уг байгууллагын үйл ажиллагаа байгаль орчин, дэлхийн дулаарлын асуудал руу түлхүү анхаарч байгаа ч үйл ажиллагаа

нь жигдэрч, оролцох гишүүн бүр нь нэгдмэл байж чадвал Зүүн Азийн Холбоо хэмээх олон улсын харилцааны хүчирхэг оролцогчдыг бий болгох боломжтой гэж олон орны судлаачид үзэж байна.

Монгол - АСЕАН-ы харилцаа

Зүүн Азийн хамтын нийгэмлэг бүрэлдэх явц нэлээд шуударч буй энэ үед АСЕАН-ы гишүүн орнуудтай хоёр талын харилцаагаа бэхжүүлэх, худалдаа, хөрөнгө оруулалтын чиглэлээр идэвхтэй ажиллах шаардлага тулгарч байна. Энэ хүрээнд АСЕАН-тай яриа хэлцээний түншлэлийн механизм бүрдүүлэх шаардлагатай байгаа бөгөөд уг асуудлыг Тайланд, Малайзын гадаад хэргийн сайд нарын айлчлалын үеэр болон Азийн хамтын ажиллагааны яриа хэлэлцээний ээлжит хурлын үеэр холбогдох талуудад тавьж ажиллаа. 2007 онд АСЕАН-ы орнуудтай улс төрийн яриа хэлцээг идэвхжүүлэх, худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаанд учирч буй саад бэрхшээлүүдийг багасгах, АПЕК-т элсэх нөхцөл бүрдүүлэх, бэлтгэл хийхэд анхаарч ажиллах зорилт тавин ажиллаж байна.¹³ Манай улс АСЕАН-ы орнуудтай хоёр талын харилцаа зарим талаар нэлээд ахицтай байлаа. Ялангуяа АСЕМ-д элсэхэд дэмжлэг авах зорилт амжилттай хэрэгжлээ.¹⁴

Сүүлийн үед Монгол Улсын төрийн дээд албан тушаалтнуудын АСЕАН-ы гишүүн орнуудад хийсэн айлчлалаас дурдвал: МУ-ын Ерөнхийлөгч 1994 онд БНСВУ, БНАЛАУ, Тайландад, 1997 онд Индонезид, 2000 онд Филиппинд, 2001 онд Сингапурт, 2005 онд БНСВУ, БНАЛАУ-д, МУ-ын Ерөнхий сайд 1995 онд Сингапур, Малайзад, 2002 онд Индонези, Сингапур, БНСВУ-д, 2005 онд Тайландад тус тус айлчилсан ба хариуд нь 1997 онд Малайзын Ерөнхий сайд, 1999, 2004 онд БНСВУ-ын Ерөнхий сайд, 2000 онд БНСВУ-ын Ерөнхийлөгч, БНАЛАУ-ын Үндэсний Ассемблейн дарга, 2003 онд Индонезийн Ерөнхийлөгч, Тайланд Вьетнамын Их Хурлын дарга нар, 2007 онд БНАЛАУ-ын Ерөнхийлөгч нар тус тус Монгол Улсад айлчлав.¹⁵

АСЕАН-ны Бүсийн Чуулган буюу АРФ нь Ази, Номхон далайн 26 улс орныг эгнээндээ нэгтгэсэн, бүс нутагт энх тайван, аюулгүй байдлыг бэхжүүлэх зорилготой олон талт яриа хэлцээний үйл явц бөгөөд манай улс 1998 онд гишүүнээр элсэн үйл ажиллагаанд нь идэвхтэй оролцож эхэлсэн юм.

2005 онд Улаанбаатар хотод зохиогдсон “АРФ-ын орнуудын аюулгүй байдлын үзэл баримтлалд гарч буй өөрчлөлт” семинар нь АРФ-д элссэнээс хойш манай улс өөртөө хүлээн авч явуулсан чухал арга хэмжээ болсон.¹⁶ 2007 оны 10 сарын 31-нээс 11 сарын 2-нд Бруней улсын нийслэл Бандар Сери Бегаван хотноо болсон АСЕАН-ы Бүсийн чуулга /АРФ/-ын чуулган хоорондын ажлын хэсгийн ээлжит уулзалтад ГХЯ-ны Олон талт хамтын ажиллагааны газрын төлөөлөгч оролцож, Ази, Номхон далайн бүс нутгийн аюулгүй байдлын зарим асуудал, тухайлбал Зүүн Хойд Азийн

аюулгүй байдлын талаарх Монгол Улсын байр суурийг илэрхийлэв. Түүнчлэн аюулгүй байдлын уламжлалт бус асуудлууд, тухайлбал хүн худалдаалах, мансууруулах бодисын наймаатай тэмцэх, онцгой байдлаас авран хамгаалах чадавхиа бэхжүүлэх чиглэлээр манай улсад авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар мэдээлж, эдгээр чиглэлд Ази, Номхон далайн бүс нутгийн орнуудтай тогтоосон хамтын ажиллагаагаа үргэлжлүүлэх сонирхолтойгоо илэрхийлсэн билээ.¹⁷

Монгол Улс Зүүн Өмнөд Азийн орнуудтай харилцаатай ба зарим орнуудтай уламжлалт, найрсаг, ойр дотно, ах дүүгийн харилцаатай явж ирсэн. Түүний нэг нь БНСВУ юм. Уламжлалт харилцааны хөрс суурийг бэхжүүлэхийн сацуу АСЕАН-ы бусад гишүүн орнуудтай харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэх, ялангуяа эдийн засаг, худалдааны салбарт урагшлуулахад Монгол Улс анхаарч ажиллаж байна.

Дүгнэлт

Эдийн засаг нь эрчимтэй өсөн нэмэгдэж байгаа АСЕАН-ы гишүүн эдгээр 10 оронтой хоёр талын хамтын ажиллагааг, ялангуяа эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэхэд анхаарч ажиллавал манай орны зах зээлд БНХАУ-ын ноёрхол тогтохоос сэргийлэхэд тус дөхөм болно гэж үзэж байна. Учир нь бидний өдөр тутмын хүнсний хэрэглээний нэг болох цагаан будаа, төрөл бүрийн хүнсний ногоо, далайн бүтээгдэхүүнүүдийг АСЕАН-ы гишүүн, дэлхийн зах зээлд цагаан будааны экспортоороо нэг, хоёрдугаар байранд ордог Вьетнам, Тайланд зэрэг орнуудаас хагас боловсруулсан болон бэлэн байдлаар нь өөрийн оронд хямд өртгөөр нийлүүлэх бүрэн боломж харагдаж байна. Ингэхийн тулд тээвэрлэлт, төмөр зам, хил гаалийн болон татварын асуудал дээр манай орон БНХАУ, БНСВУ-тай хоёр, гурван талын хэлэлцээр хийх нь зүйтэй.

Эцэст нь дүгнэж хэлэхэд, АСЕАН-тай албан ёсны харилцаа тогтоон хамтарч ажиллах, ингэснээр өөрийн орны эдийн засаг, улс төрийн харилцаанд эерэг чиг хандлагыг бий болгохын тулд манай улс АПЕК-т элсэхийг зорин ажиллаж байгаа энэ үед АСЕАН-ыг гуравдагч хөрш гэж үзэж албан ёсны харилцаагаа нилээд өргөжүүлэхийн зэрэгцээ тус байгууллагын гишүүн орнуудтай харилцаа, хамтын ажиллагаагаа хөгжүүлэх, улмаар манай улс АПЕК-т элсэхэд тэдгээрийн АСЕАН-ы гишүүн орнуудын дэмжлэгийг олж авах нь бидний гол зорилго юм.

ЭШЛЭЛ, ЗҮҮЛТ

1. Бор,Ж., *Монголын Дипломат Товчоо*, Улаанбаатар, 2004 он. 207-р тал.
2. Тухайн үеийн гадаад бодлогын шийдвэр гаргагчид
3. Мөнх-Очир.Д., *“Монгол Улсын аюулгүй байдлын гадаад орчин ба Монголын Зэвсэгт хучний шинэчлэл, сорилтууд”* лекц, Улаанбаатар, 2006 оны 4 сар
4. *Монгол Улсын гадаад бодлогын хөх ном 2006*, Улаанбаатар, 11-р тал.
5. Мөн тэнд, 101-р тал.
6. <http://www.aseansec.org>
7. БНСВУ-БНХАУ хооронд эзэмшлийн маргаан байдаг.
8. <http://www.aseansec.org>
9. С.Дашцэвэл.С., *Зуун Өмнөд Азийн хөгжлийн хандлага, интеграци, Монгол Улсын бодлого чиглэл*, Улаанбаатар, 2005 он, 43-р тал.
10. Мөн тэнд, 45-р тал.
11. *Ази тив, түүний салбар бус нутгуудын хамтын ажиллагаанд Монгол Улсын оролцоо, хэтийн төлөв*, Улаанбаатар, 1997 он, 57-р тал.
12. <http://www.aseansec.org>
13. ГХЯ-ны 2006 оны үйл ажиллагааны тайлан, *Гадаад харилцаа: Монгол Улсын ГХЯ-ны мэдээллийн товхимол*, Улаанбаатар, 2 (2007), 15-р тал.
14. Мөн тэнд, 32-р тал.
15. *Монгол Улсын гадаад бодлогын хөх ном 2006*, Улаанбаатар, 25-р тал.
16. Мөн тэнд, 65-р тал.
17. <http://www.mofa.gov.mn>

Хавсралт №1

АСЕАН-ны гишүүн орнуудын ерөнхий үзүүлэлтүүд

	АСЕАН-ы элсэн ойн **	Газар нутаг /км ² /	Хүн ам /сая/ /сая ам.доллар/ ДНБ	ДНБ-ний өсөлт	I хэмжээний ДНБ I хэмжээ ноглох ДНБ	Инфляци	Хөрөнгө оруулалт /ДНБ/ Хөрөнгө оруулалт	Ажиллах хүч /сая/ Ажиллах хүч	Экспорт /тэрбум ам.доллар/ Экспорт	Импорт /тэрбум ам.доллар/ Импорт	
Сингапур	1967	692,7	4.5	132.3	7.9%	31400	1%	23.1%	2.5	289.4	244.6
Малайз	1967	329,750	24.8	149.7	5.9%	12800	3.6%	20.9%	10.7	160.8	124.0
Филиппин*	1967	300,000	86.9	117.1	5.4%	5000	6.2%	14.6%	35.8	47.2	51.6
Тайланд*	1967	513,000	65.2	206.5	4.8%	9100	5.1%	28.7%	30.4	123.5	119.3
Индонези*	1967	1,891,000	222.1	364.3	5.4%	3800	13.2%	20.3%	106.4	102.3	77.8
Брүней*	1984	5,800	0.4	11.9	0.4%	25600	1.1%	-	0.2	6.3	1.5
Вьетнам	1995	329,560	85.3	61.1	8.2%	3100	7.5%	32.3%	44.6	39.9	40.6
Бирм*	1997	677,000	57.3	12.1	2.6%	1800	21.4%	11.8%	28.5	3.6	2.1
Лаос*	1997	237,000	6.2	3.5	7.2%	2100	6.8%	-	2.1	1.1	1.4
Кампучи	1999	181,040	14.1	6.1	10.5%	2800	4.7%	19.3%	7.0	3.7	4.8
АСЕАН*	-	4,465,500	567.4	1,064.6	5.8%	9392	7.08%	-	268.0	776.5	667.7

www.cia.gov CIA fact book 2007 оны 12 сарын 13

*www.aseansec.org ASEAN Statistic

**ГХЯ, Монгол Улсын Гадаад бодлогын хөх ном, УБ, 2006 он

Хавсралт №2

Монгол ба АСЕАН-ны харилцаа, гадаад худалдаа

/мянган ам.доллар/

	МУ-тай догоовот харилцаа тогтоосон он*	Экспорт						Импорт					
		2005 I-XII	2006 I-XII	2006 HX	2006 IX	2007 HX	2007 IX	2005 I-XII	2006 I-XII	2006 HX	2006 IX	2007 HX	2007 IX
АСЕАН	-	707.4	2406.8	1378.8	253.2	681.0	3.9	31,174.2	40,587.0	27,885.9	3,908.0	43,583.7	4,232.3
Вьетнам	1954	32.4	8.4	8.0	8.0	-	-	2,500.0	2,901.0	2,204.0	319.0	3,974.9	730.5
Индонези	1956	26.9	6.5	6.5	-	-	-	3,227.1	3,679.7	2,002.4	215.5	2,370.3	324.4
Бирм	1956	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Кампучи	1960	-	28.6	-	-	259.0	-	0.6	4.2	-	-	22.7	-
Лаос	1962	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Сингапур	1970	611.3	2321.0	1357.7	245.1	419.4	3.9	10,270.0	20,727.0	13,610.5	2,241.2	17,900.5	1,727.0
Малайз	1971	0.9	42.2	6.5	-	2.6	-	930.1	9,752.1	956.0	908.5	13,465.3	503.5
Филиппин	1973	3.3	0.1	-	-	-	-	1,270.4	1,101.4	1,024.2	154.2	82.9	149.7
Тайланд	1974	32.9	-	-	-	-	-	804.9	2,101.0	1,580.8	9.0	5,081.1	490.3
Брүней	1984	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-

*ГХЯ, Монгол Улсын Гадаад бодлогын хөх ном, УБ, 2006 он

www.nso.mn Монголын Үндэсний Статистикийн Газрын мэдээлэл, 2007 он